



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/59

Хажуу шинэ-Ус

Ажил хүлээн авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны 05 дугаар сарын 30-ний өдөр Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газар, "Эхний эхэн" ххк-тай байгуулсан Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Өрнөлт багийн хүлэмжийн хашаанд гүн өрмийн худаг шинээр гаргах ажлын гүйцэтгэлийн ажил үйлчилгээнд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах, гүйцэтгэлийг хүлээн авах эрх бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Даваасүрэн (Засаг даргын орлогчийн үүргийг түр хавсран гүйцэтгэгч)

Нарийн бичиг: Л.Батбаатар (4 дүгээр багийн Засаг дарга)

Гишүүн: Н.Ганбат (Санхүү албаны дарга)

2. "Эхний эхэн" ххк-тай хүлээн авах ажлыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтод үндэслэн нэр төрөл, хэмжих нэгж, тоо ширхэг, хүчин чадал бүрээр нь акт үйлдэн хүлээн авч үндсэн хөрөнгөд бүртгэхийг Санхүү албаны дарга (Н.Ганбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА Т.АРИУНАА

